



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн "Гүүдсек ҮЦК" ХК-ийн ажилтан А.Ганчимэгт үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжаа бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000315